



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын гол дүгнэлт: Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

Тайланг

хүргүүлсэн этгээд:

Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар

**Нэмэлт мэдээлэл,
хаяг:**

Дорнод аймаг, Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2-р байр, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар, 7058-4207

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дүгээр тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.

Аудитын харилцан хамаарал: (Сэдвийн ач холбогдол болон аудит хийх болсон шалтгаан нөхцөл байдал болон хүлээгдэж буй эрсдэлийн тухай бичнэ.)

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 30, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 705, шинээр 664, нийт 6,152.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1369 төсөл, арга хэмжээг 1,393.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 513.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 680 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын шийдвэр болон төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосон байна.

Улсын төсвөөр Дорнод аймагт 2022 онд нийт 49.6 тэрбум төгрөгийн 38 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталж, шинээр 9.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж, өмнөх оноос шилжиж ирсэн 21.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 2022 онд 11.1 тэрбум (шинэ 3.1 тэрбум, шилжих 8.0 тэрбум төгрөг) төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

Дорнод аймгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр нийт 6.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 63 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс 2022 онд 4.5 тэрбум (шинэ 4.3 тэрбум, шилжих 0.2 тэрбум төгрөг) төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна. Тайлант онд буюу 2022 онд аймгийн төсөвт 3 удаа тодотгол, өөрчлөлт хийж задарсан дүнгээр 7.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 67 төсөл, арга хэмжээ хэрэгжжээ.

Нэгдсэн төлөвлөгөөт аудитын хүрээнд орон нутгийн хөгжлийн сан, авто зам, байгаль хамгаалах сан, хөрөнгө оруулалтын бус болон сумдын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулаагүй болно.

Аудитад дараах эрсдэлүүдийг хамгийн “Өндөр” гэж тооцож төлөвлөсөн болно. Үүнд:

- Санхүүжилтийг төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжгүй байдлаар баталсан байх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байх,
- ТШӨХ-д заасан шалгуур үзүүлэлт нь барилга байгууламжийн хүчин чадал, хэмжээ, төвөгшилтэй уялдаагүй байх, /хэт өндөр эсвэл нам шалгуур тавьсан/,
- Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслээгүй олгосон, эсвэл хугацаанд нь олгоогүй байх
- Үндэслэлгүйгээр нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан байх
- Төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй орхигдож, олон жил үргэлжлэн үргүй зардал гарсан байх
- Хүлээн авсны дараах ашиглалтын зардал, ашиглах боловсон хүчин, бүтэц орон тоо батлагдаагүй байх
- Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байх
- Худалдан авах ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулагдаагүй байх
- Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнгүй байх

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;

Аудитад Дорнод аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2022 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, сумдын Засаг дарга нар, захиалагч байгууллагууд, хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл:**Аудитын гол үр дүн:**

А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль болон хөгжлийн бодлогын баримт бичигтэй бүрэн нийцүүлээгүй байна.

А.1. Төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй харилцан адилгүй уялдсан байна.

А.2. Төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуульд нийцүүлээгүй төлөвлөсөн байна.

- Орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээ нь улсын төсөвт тусгагдаагүй байна.

- Хөрөнгө оруулалтын ашиглалтын зардал, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоогүй байна.

Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ хууль журам, гэрээний заалтыг баримтлаагүй байна.

Б.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

- Үнэлгээний хороод нь эрх шилжин ирсэн зарим тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.

Б.2. Зарим төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй зөрчил илэрч байна.

- Гэрээний хугацаанд дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна.

Б.3. Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгоогүй байна.

- Журамд заасан хугацаанд гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг олгоогүй байна.

Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй хэрэгжээгүй байна.

- Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан хуулийн этгээдтэй зохиогчийн хяналтын гэрээ байгуулсан байна.

- ТЕЗ-ийн дотоод хяналтын дүгнэлт гараагүй байна.
- Б.5. Төсөл арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан ч ашиглалтгүй 2 тоног төхөөрөмж байна.
- Ашиглалтад хүлээн авсан 50.0 сая төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг аудитын явцад данс бүртгэлд тусгасан байна.

В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.

- Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцээгүй 430.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд нийцүүлж төлөвлөөгүй байна.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

- Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

- Төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод нийцээгүй зөрчлүүд илэрч байна.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар журамд зохицуулсан зүйл, заалт тусгагдаагүй байна.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт тайлант хугацаанд хэрэгжиж дуусаагүй байна.

- Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагаа хангалтгүй байна.

- Төсвийн ерөнхийлөн захирагч нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг байршуулахдаа хугацаа хэтрүүлсэн байна.

Аудитын дүгнэлт:

А.1. Төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй харилцан адилгүй уялдсан байна.

- Тухайлбал төлөвлөж, баталсан төсөл, арга хэмжээнүүд нь “Алсын хараа 2050”-д 97.5, Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 85.4 хувь нь тус тус нийцсэн байхад аймгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 95.2 хувь нь нийцсэн нь харилцан уялдаагүй төлөвлөснийг харуулж байна.

А.2. Төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуульд нийцүүлээгүй төлөвлөсөн байна.

- Орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээ нь улсын төсөвт тусгагдаагүй байгаагаас гадна хөрөнгө оруулалтын ашиглалтын зардал, төсөвт нөлөөлөх ачааллыг орон нутгийн түвшинд огт тооцож үзэхгүй байна.

Б.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

- Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороод нь эрх шилжин ирсэн зарим тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.

Б.2. Зарим төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй зөрчил илэрч байна.

- Эрх нь шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хувьд гүйцэтгэгч гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй зөрчил илэрсэн. Санхүүжилт, тендер, хяналтууд нь холбогдох яамдаас хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдэд гүйцэтгэгчээс гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй 5, мөн ашиглалтын шаардлага хангахгүй 1 төсөл, арга хэмжээ байна.

Б.3. Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгоогүй байна.

- Төсөл арга хэмжээний тоног төхөөрөмжийн хяналтын хуудсыг хөтлөөгүй, эрх нээх мэдэгдэл гаргаагүй, санхүүжилтийг дутуу, журмын хугацаанаас хоцроож олгож байгаа зөрчлүүд гарч байна.

Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй хэрэгжээгүй байна.

Б.5. Төсөл арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан ч ашиглалтгүй 2 тоног төхөөрөмж байна.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.

- Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцээгүй 430.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ байна.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд нийцүүлж төлөвлөөгүй байна.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

- Үүнд худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод нийцээгүй, санхүүжилтийг олгохдоо Засгийн газраас баталсан журмыг баримтлаагүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хэрэгжиж дуусаагүй, хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагаа хангалтгүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

Аудитаар нийт 2,035.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 1,549.6 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 403.5 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгч, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх 2 санал, нэгтгэсэн тайланд тусгуулан холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлэх 81.9 сая төгрөгийн 4 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

Аудитын зөвлөмж:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. А.1.1-А.1.2. Төсөл, арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийцсэн төсөл, арга хэмжээг төлөвлөх талаар Сангийн яаманд уламжлах.
2. А.2.2. УИХ-ын гишүүд болон салбарын сайд нарын хөрөнгө оруулалтын багцад багтсан хөрөнгө оруулалтыг тухайн орон нутгийн ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын жагсаалтад эрэмбэлсэн эсэхийг тулган баталгаажуулж улсын төсөвт тусгах талаар УИХ-д уламжлах.
3. Б.3.1. “Аймаг, сумын Засаг даргын тамгын газрын тоног төхөөрөмж”-ийг нийлүүлсэн “Иххалх нөмрөг” ХХК-д олгох санхүүжилтийн үлдэгдэл 81.9 сая төгрөгийг шийдвэрлэх талаар Сангийн яаманд уламжлах.
4. В.2.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зохицуулах талаар журам баталж мөрдүүлэх талаар Сангийн яаманд уламжлах.

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. А.2.4. Төсвийн тухай хуулийн 6.2.4, 29.2 дахь хэсэгт зааснаар төсөл, арга хэмжээний ашиглалтын зардал, орон тоог санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг төсөвт нөлөөлөх ачааллын тооцоог хийж дүгнэлт гаргаж ажиллах.
2. Б.2.1. Төсөл, арга хэмжээний гэрээг сунгахдаа мэргэжлийн байгууллагын дүгнэлт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4 дэх заалтыг баримтлах.
3. Б.4.2. В.2.4 дэх асуудлуудтай хамааруулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд хийх дотоод хяналтыг дараа оны 1 дүгээр улиралд багтаан дуусгаж, дүгнэлтийг танилцуулж байх талаар ТЕЗ-ийн дотоод аудитад чиглэл өгөх.
4. В.2.5. Төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээж авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, ашиглалтыг сайжруулах.
5. В.2.6. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасны дагуу шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэх зарчмыг хэрэгжүүлэх.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Д.Дамдинбазарт:

1. Б.2.1. В.2.2. Захиалагч, гүйцэтгэгчдийн хооронд байгуулсан гэрээний хугацааг чанд мөрдүүлж, гэрээний хугацаанд дуусгаагүй төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулах. /Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд хамаарна./
2. Б.4.1. Аж ахуйн нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацаа, бусад шалгуурыг хангуулсны үндсэн дээр зохиогчийн хяналтын гэрээг байгуулж байх.

Хавсралт:**Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл**

Аудитаар нийт 2,035.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 1,549.6 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 403.5 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгч, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх 2 санал, нэгтгэсэн тайланд тусгуулан холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлэх 81.9 сая төгрөгийн 4 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн дүн /сая.төг/		Үүнээс			Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	
А	1	2	3	4	5	6	7
1	Аймгийн Засаг дарга	9	1,620.6	5		4	
2	ГХБХБГ	2	332.5	2			
	ДҮН	11	1,953.1	7		4	